

Сэдэв: Бизнесийн орчин дахь цахим залилан, тэдгээрээс урьдчилан сэргийлэх практикт ашиглах боломжтой энгийн аргууд

2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Нэр: Ж.Дөлгөөн

Ажил: “НОМИН Холдинг” ХХК-ийн гадаад гэрээний хуульч

Сүүлийн 2 жилийн хугацаанд Ковид-19 цар тахлын улмаас бизнесийн орчин дахь бүх харилцаа цахим болон зайнаас хэлбэрт шилжсэн. Үүний улмаас харилцагч аж ахуйн нэгж, иргэнтэй биечлэн уулзаж, гэрээ, хэлцэл байгуулах боломжгүй нөхцөл байдалд хүрч байна. Холбогдох хууль тогтоомжууд ч мөн энэхүү нөхцөл байдалтай уялдан өөрчлөгдөн шинэчлэгдсэн. Тухайлбал, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр өөрчлөн найруулсан Монгол Улсын Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42¹.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол цахим хэлбэрээр хийх хэлцэл нь талууд хүсэл зоригоо харилцан илэрхийлж, цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурснаар, эсхүл бусад байдлаар техникийн хэрэгсэл, программ хангамжийг ашиглан хүсэл зоригоо илэрхийлж, харилцан хүлээн зөвшөөрч, цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.” гэж заасны дагуу цахимаар хэлцэл хийхийг хүлээн зөвшөөрсөн нь бизнесийн орчин дахь худалдааны эрх зүйн хөгжилд том хувь нэмэр оруулсан.

Гэвч сайны хажуугаар саар гэгчээр бүх зүйл цахимжихын хэрээр цахим орчныг ашиглан санхүүгийн гэмт хэрэг үйлдэх оролдлогууд улам бүр нэмэгдэж байна. Иймд аж ахуйн нэгжүүд харилцагч компани, иргэнийг бодит нийлүүлэгч, үйлдвэрлэгч мөн эсэхийг нягтлан шалгах, эрсдэл үнэлэх ажиллагааг сайжруулах шаардлага тулгарч байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр олон нийтэд танилцуулсан Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалтад орсонтой холбогдуулан шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын жагсаалтын¹ 3 дугаар хэсэгт Мөнгө угаах гэмт хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн статистик мэдээллээр “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Хамтын ажиллагааны зөвлөлийн Хууль сахиулах байгууллагуудын Шууд хэрэгжилт-7 (Ю-7) Ажлын хэсэгт шүүхээр шийдвэрлэсэн мөнгө угаах дан болон давхар зүйлчлэлтэй гэмт хэргийн судалгааг нийт 6 удаа гаргасан ба шүүхээс мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн статистик тоон мэдээг үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт өмнөх жилүүдээс өссөн байна.”

¹ http://www.judgcouncil.mn/site/news_full/10769 Нэвтэрсэн огноо: 2021/09/24 14:25 минут.

№	Тайланд хүргүүлсэн хугацаа	Судалгааны хамрах хугацаа	Судалгааны товч
1	2019 оны 7 дугаар сар	2017-2019.7.11	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор нийт 44, давж заалдах шатны шүүхээр 17, хяналтын шатны шүүхээр 2 мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэгдсэн.
2	2019 оны 12 дугаар сар	2019.7.11-2019.12.02	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор нийт 20 мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэгдсэн.
3	2020 оны 1 дүгээр сар	2019.12.03-2020.01.03	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр нийт 2 хэрэг хянан шийдвэрлэгдсэн, үлдэгдэл 10.
4	2020 оны 3 дугаар сар	2020.01.03-2020.3.18	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 14, давж заалдах шатны шүүхэд 5, хяналтын шатны шүүхэд 2 хэрэг нийт 21 мөнгө угаах гэмт хэрэг хянан шийдвэрлэгдсэн.
5	2020 оны 5 дугаар сар	2020.3.18-2020.5.	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор нийт 14 мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэгдсэн.
6	2020 оны 8 дугаар сар	2020.4.13-2020.8.13	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр нийт 37 хэрэг хянан шийдвэрлэгдсэн, үлдэгдэл 15. ²

Энэхүү тайлангаас үзэхэд санхүүгийн гэмт хэргийн гаралт улам ихэссэн байна. Бизнесийн орчинд хамгийн түгээмэл гарч буй цахим залилангийн оролдлогуудыг өөрийн туршлагаас хуваалцвал,

1. Гадаадын томоохон бэлтгэн нийлүүлэгчийн нэрийг барьж гэрээ хэлцэл байгуулахаар оролдох, улмаар урьдчилгаа төлбөр шилжүүлж авахаар оролдох.
2. Хуурамч и-мейл, аккаунт ашиглан удаан хугацаанд хамтран ажилласан харилцагч компанийн данс ямар нэг шалтгаанаар өөрчлөгдсөн тухай албан ёсны тамга тэмдэгтэй мэдэгдлээр бус и-мейлээр мэдэгдэж /тухайлбал, аудитын шалгалт орж байгаа тул дансыг түр түдгэлзүүлсэн, Саудын Араб Улсад үйл ажиллагаа явуулдаг харилцагч мөнгө шилжүүлсний улмаас терроризмтой тэмцэх хэлтсээс шалгалт хийж дансыг түдгэлзүүлсэн гэх мэт/, шинэ дансны мэдээлэл илгээх.

² Шүүхийн Ерөнхий Зөвлөл. “Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалтад орсонтой холбогдуулан шүүхийн ерөнхий зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын танилцуулга”-ын 3 дугаар хэсэг. Мөнгө угаах гэмт хэргийг шүүхээс хянан шийдвэрлэсэн статистик мэдээлэл. 2020/09/30

3. Шинээр байгуулагдсан компаниуд зах зээлийн үнээс хэд дахин хямд үнээр хамтарч ажиллах санал тавих.

4. Урьдчилгаа төлбөр шилжүүлэн авсны дараа гэрээгээр хүлээсэн үүргээ ямар нэг шалтгаанаар биелүүлэхгүй байх. /Тухайлбал, үйлдвэрт засвар хийж байгаа, тухайн улсын ХАҮТ-ын гэрчилгээгүйгээр давагдашгүй хүчин зүйл учирсан гэж мэдүүлэх, дампуурах гэж байгаа гэх мэт./

Компани бүр мэдээлэл технологийн газар, эрсдэлийн удирдлагын газар, эрх зүйн газартай биш тул эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх байнгын чиг үүрэг бүхий газар, хэлтэс, ажилтныг ажиллуулах боломжгүй байдаг. Тэгвэл заавал мэргэжлийн мэдлэг шаардахгүйгээр эдгээр залиланг танин мэдэж болох энгийн аргуудыг танилцуулъя.

1. Анх удаа харилцаж байгаа компанийн хувьд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сангаас тухайн компанийн мэдээллийг шүүж харах: Монгол Улсын хувьд <http://opendata.burtgel.gov.mn/les> сайтаас тухайн компанийн регистрийн дугаар эсхүл оноосон нэрээр шүүлт хийх ба компанийн хаяг, үйл ажиллагааны төрөл, итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл харагдах боломжтой. Иймд тухайн компани дампуурсан эсэх эсхүл хамтран ажиллах санал тавьж буй этгээд, гэрээнд гарын үсэг зурж буй этгээд нь хууль ёсны эсэхийг мэдэх боломжтой болох юм. Ингэснээр гэрээ нь хүчин төгөлдөр бус болохоос сэргийлэх ач холбогдолтой.

Гадаадын ихэнх улс орнуудад дээрхтэй адил компанийн бүртгэлийн мэдээлэл шалгах засгийн газрын албан ёсны веб хуудас байдаг ба тийм веб хуудаснаас тухайн харилцагч компани, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн мэдээллийг олох боломжтой. Тухайлбал, Бүгд Найрамдах Польш Улсын компани бол <http://www.krs-online.com.pl/> , Бүгд Найрамдах Сингапур Улсын компани бол <https://opengovsg.com/corporate/> , Швейцарын Холбооны Улсад үйл ажиллагаа явуулдаг компани бол <https://www.uid.admin.ch/> веб сайтаас хуулийн этгээдийн мэдээллийг шалгах боломжтой.

2. Тухайн харилцаж буй и-мейл хаягийг албан ёсны и-мейл хаяг мөн эсэхийг шалгах: Ихэнх томоохон компаниудын хувьд хэзээ ч @gmail.com, @yahoo.com зэрэг хаягийг ашигладаггүй. Тухайн компанийн албан ёсны домайн хаяг бүхий и-мейлийг ашигладаг. Тухайлбал @kernfloor.com, @times.pl гэх мэт. Хэрэв томоохон компаниас дээр дурдсан хувийн и-мейлээс данс өөрчлөгдсөн тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд албан ёсны и-мейлээр энэ талаар мэдэгдэхийг хүсэхэд болно.

Хэрэв албан ёсны домайн эзэмшдэггүй, жижиг компанитай хамтран ажилладаг бол урьд нь харилцаж байснаас өөр хаягаар мэдэгдэл ирвэл нэн тэргүүнд өмнө харилцаж байсан хаяг руу энэ талаар мэдэгдэх, интернет эх сурвалжаас албан ёсны и-мейлийг олж

энэ хаяг танай хаяг мөн үү? Энэ хүн танай ажилтан мөн үү? Ийм данс өөрчлөгдсөн тухай мэдэгдэл манайд ирлээ. Үнэн үү? гэж давхар шалгах, эсхүл утсаар ярьж лавласан ч болно. Хэдийгээр бизнест цаг, минут, секунд бүр үнэ цэнэтэй байдаг ч цахим залилан, луйварт өртсөнөөс лавлаж баталгаажуулах нь илүү бага эрсдэл авчирна. /Жич: Данс өөрчлөгдсөн тухай мэдэгдсэн и-мейл хаягийг үг, үсэг, тэмдэгт, тоо, цэг таслалгүй нарийн шалгах шаардлагатай. Ихэнх цахим залилангийн хувьд нэг үсэг, нэг тэмдэгтийн зөрүүтэй и-мейл бичиж ажилтныг төөрөгдүүлдэг. Тухайлбал, Bestbuyinfo@Fashionlab.com - Bestbuyinfo@Fashionlab.com энэ 2 и-мейл хаягаас жижиг 'l' /эл/ үсгийг том 'L'/ай/ үсгээр сольсныг анзаарахгүй байх магадлалтай./

3. Хэрэв данс өөрчлөгдсөн тухай мэдэгдсэн тохиолдолд энэ талаар и-мейлээр биш албан ёсны мэдэгдэл/ an official letter-ээр эсхүл гэрээнд нэмэлт өөрчлөлт/ an amendment to contract оруулах: Анх гэрээ байгуулахдаа талуудын албан ёсны холбоо барих мэдээлэл хэсэгт өөрийн болон харилцагч компанийн албан ёсны төлөөлөгч, түүний холбоо барих мэдээлэл, утас, и-мейл зэргийг зааж өгөх нь ач холбогдолтой. Мөн мөнгө хүлээн авах дансны мэдээллийг инвойсоор биш үндсэн гэрээнд оруулж өгөх шаардлагатай. Тухайлбал,

“2.1. Гэрээний төлбөрийг Худалдан авагч тал нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Худалдагч талын банкны ... тоот дансанд шилжүүлэх ба гэрээний төлбөрт НӨАТ багтсан болно.

2.2 Энэхүү гэрээний 2.1-т заасан Худалдагч талын мөнгө хүлээн авах данс өөрчлөгдсөн тохиолдолд Худалдагч тал энэ талаар Худалдан авагчид бичгээр мэдэгдэж, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.” гэж оруулснаар заавал харилцагч компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэгтэй, компанийн бланктай, тамга тэмдэгтэй мэдэгдлийг үндэслэн төлбөр шилжүүлэх ба энэ тохиолдолд залилагч этгээд эдгээрийг бүгдийг хуулбарлах боломжгүй юм.

4. Дансны мэдээллийг шалгах: Монгол Улсад интернет банкаар нэг банкны данс хооронд мөнгө шилжүүлэхэд данс эзэмшигчийн нэр гарч ирдэг. Харин төлбөр хүлээн авагч гэрээнд тусгаагүй тохиолдолд өөр этгээдийн дансаар эсхүл гэрээнд зааснаас өөр дансаар төлбөр хүлээн авах тохиолдолд төлбөрийг тухайн дансаар авах болсон тухай бичгээр мэдэгдэхийг шаардах нь зүйтэй. Гадаад харилцагчдын хувьд данс эзэмшигчийн мэдээлэл нь ихэвчлэн хувийн мэдээлэл байх тул нэвтрэн шалгах боломжгүй байдаг.

Дийлэнх гадаад гүйлгээг хийхэд свифт шаардлагатай ба харилцагчаас ирүүлсэн свифтийг google хайлтын систем дээр хайхад мөнгө хүлээн авагч банкны нэр, хаяг, салбарын нэр гарч ирнэ. Жишээлбэл, PPAВPLPK **свифтийг авч үзье.**

Detailed information about SWIFT Code PPABPLPK

SWIFT Code PPABPLPK

Money Transfer Save on international fees by using [Wise](#)

Receive Money Get paid at the real exchange rate by using [Wise](#)

Bank BNP PARIBAS BANK POLSKA S.A.

Address KASPRZAKA STREET 10/16

City WARSZAWA

Branch Centrala

Postcode 01-211

Country Poland³

Хэрэв мөнгө хүлээн авах банк нь харилцагчийн үйл ажиллагаа явуулдаг улсаас өөр улс, эсхүл өөр муж байгаа бол энэ нь цахим залилан байх боломжтой.

Эдгээр энгийн аргууд нь нарийн мэргэжлийн ур чадвар шаардахгүй тул бизнес эрхэлдэг бүхий л этгээд: иргэн, аж ахуйн нэгж ашиглан өөрсдийгөө цахим залилангаас хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой. Дижитал эрин рүү хөл нийлүүлэн алхаж яваа өнөө үед бүх харилцаа цахимжиж, бизнесийн төрөл бүрийн уулзалт онлайнээр зохион байгуулагдаж, гэрээ хэлцлийг цахимаар хийж байгаа нь маш том давуу тал боловч цахим орчныг ашиглан хууль бусаар мөнгө олох гэсэн увайгүй үйлдлүүд газар авч байгаа тул хэн бүхэн өөрсдийгөө цахим санхүүгийн гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх энгийн аргуудыг мэддэг байх шаардлага тулгараад байна. Иймд бизнесээ ч амжилттай явуулж, дотоодын болон гадаадын түнш компаниудтай хамтран ажиллахын зэрэгцээ өөрийгөө, компаниа, харилцагчаа, ажилчдаа эрсдэлээс урьдчилан сэргийлж чаддаг байвал та жинхэнэ ОРЧИН ҮЕИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ юм.

³ <https://bank.codes/swift-code/poland/ppabplpk/> веб хуудас. Нэвтэрсэн огноо: 2021/09/24 15:59 минут.